



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар: ТУЗ/03/02

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал худалдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 60, 62 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, 7.3 дах хэсэг, 8-р зүйлийн 8.9.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 сарын 30-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороолол, 3 дугаар хороо, Гоёо ХХК-ийн үйлдвэрийн байрны 1 давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр баталсугай.

2.1 Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлах

2.3 Компанийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулах

2.4 Компанийн 2018 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

2.5 Компанийн 2019 оны санхүүгийн төлөвлөгөөг батлах

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт 1-ээр баталж, 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт 2-оор баталж 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байхаар тогтоосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ын гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг

томилсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Т.Солонго Б.Үйлсдэлгэр Нягтлан бодогч Д.Энхгэрэл нарыг тус тус томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Ё.Ганбатыг томилон, хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрсүгэй

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН

ГИШҮҮД:

Д.ХУЛАН

Ч.ВАНЧИН-ЭРДЭНЭ

Ц.ОЮУНЦЭЦЭГ

Ц.ЦЭЦЭНХҮҮ

Ц.ОРГИЛБОЛД

Я.ПҮРВЭЭ

Д.БАЙГАЛЬМАА

Ж.МЯГМАРСҮРЭН